

Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан

Эрүүл мэндийн яам

2022 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах								
1		1.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube),	2022 он				Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube), лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулсан. Үүнд: - Албан ёсны цахим хуудсаараа давхардсан тоогоор 51 мэдээлэл, 4 баннер, 17 шторкыг түгээсэн байна -Нийгмийн сүлжээгээр 2 баннер, 31 шторкыг түгээсэн байна -72 сурталчилгааны салбарт мэдээлэл байршуулсан байна. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн хамтран ажиллах тухай албан бичгийн дагуу АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар пэйж хуудсыг идэвхтэй дагах тухай дотоод меморандумыг Газар, хэлтэст хүргүүлж, яамны дотоод сүлжээнд байршуулсан. Мөн харьяа агентлаг, эрүүл мэндийн байгууллагад тус хуудсуудыг дагаж, хамтран ажиллах тухай 2/1356 тоот албан бичгийг 2022 оны 3 дугаар 28-ны өдөр хүргүүлсэн. Тус албан бичгийн дагуу эрүүл мэндийн яамны харьяа 24 байгууллага цахим хуудастаа Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа гэсэн цэсийг нэмж, мэдээллээр баяжуулан ажиллаж байна. Тус албан бичгийн дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын Үндэсний төв зэрэг томоохон эмнэлгүүд "Авлигад үгүй гэж хэлье" уриатай QR код бүхий зурагт хуудсыг	100%

		лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх.				бэлдэж, цахим хуудаастаа байршуулсан. Улсын хоёрдугаар төв эмнэлгээс Авлигатай тэмцэх газартай хамтран Авлигатай тэмцэх газраас 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Хүнд суртал, чирэгдэлгүй цахим үйлчилгээ” өдөрлөг арга хэмжээнд зориулсан шторкыг эмнэлгийн 8 албан хаагчидтай хамтран бэлтгэсэн. АТГ-аас 2022 оны 08 дугаар сарын 25-нд цацагдсан “Хамран сургах тойргийн сургуульд цэцэрлэгт нь хүүхдүүдээ хамруулах” тухай шторк-д тус эмнэлгийн Нэгдсэн лабораторийн тасгийн их эмч С.Батцэцэг хамтран бэлтгэсэн. Хавсралт : 20 зураг	
2		1.2. АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах.	2022 он			Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн хамтран ажиллах тухай албан бичгийн дагуу АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар пэйж хуудсыг идэвхтэй дагах тухай дотоод меморандумыг Эрүүл мэндийн яамны газар, хэлтэст хүргүүлж, яамны дотоод сүлжээнд байршуулсан. Мөн харьяа агентлаг, эрүүл мэндийн байгууллагад тус хуудсуудыг дагаж, хамтран ажиллах тухай 2/1356 тоот албан бичгийг 2022 оны 3 дугаар 28-ны өдөр хүргүүлсэн. Тус албан бичгийн дагуу дараах ажлууд хийгдсэн. Үүнд: Авлигатай тэмцэх газраас санаачлан зохион байгуулж буй "Зөв зөвд шударга зөв" аяны хүрээнд УНТЭ-т "Зөв зөвд шударга зөв" аяны удирдамжийг 2022.04.01-ний өдөр батлуулан 2 сарын хугацаанд холбогдох ажлыг зохион байгуулан ажилласан. Аяны хүрээнд АТГ-аас санаачлан хэрэгжүүлж буй үйл ажиллагааг дэмжин ажиллах - Авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлан таниулах, үнэн зөв мэдээ мэдээллийг бодит эх сурвалжаас түгээх зорилготой "Авлигатай тэмцэх газар" пэйж хуудас, "АТГ-Олон нийтийн төв" фэйсбүүк пэйж хуудсыг нэгдэн дагахыг нийт ажилтнууддаа уриалж ажилласан. Тус хуудсыг дагахыг нийт ажилтнуудад Камертон хамтлагийн дуучин Л.Ган-Эрдэнээр сурталчуулан үр дүнтэй ажилласан. Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс "Авлигад үгүй гэж хэлье" нэртэй зурагт хуудсыг бэлтгэн цахим хуудаастаа байршуулсан. Мөн 2022 оны 12 дугаар сарын 09-ний "Авлигын эсрэг өдөр"-ийн хүрээнд Авлигатай тэмцэх газрын 110 зурагт хуудсыг Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл	100%

						мэндийн байгууллагууд дэмжин албан ёсны цахим хаяг, фэйсбүүк хуудастаа байршуулж, түгээсэн. Хавсралт : 18 зураг	
3	1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах.	2022 он				Авлигатай тэмцэх газраас 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэнсурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарыг Эрүүл мэндийн яаманд байршуулсан. Иргэдээс Эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдад Авлигатай холбогдуулан гаргасан гомдол байхгүй байна. Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллагууд "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" самбарыг мөн ажиллуулж, эмнэлгээр үйлчлүүлж буй иргэдэд Авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг түгээн ажиллаж байна. Хавсралт : 15 зураг	100%
2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг сургалтад хамруулах							
4	2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар АТГ-т хүргүүлж, албан хаагчдаа холбогдох сургалтад хамруулсан байх.	2022 он				Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Сургалтын төлөвлөгөөг хүлээн авч, төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг сургалтад хамруулж байна. Эрүүл мэндийн яамны хувьд дараах сургалтуудад хамрагдсан байна. Үүнд: 1.2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр цахимаар зохион байгуулагдсан шинэ албан хаагчдад зориулсан сургалтад нийт 15 албан хаагчийн квот өгөгдсөн бөгөөд дараах нэр бүхий албан хаагчид хамрагдсан байна. 2. 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр цахимаар зохион байгуулагдсан авлигын эсрэг давтан сургалтад дараах нэр бүхий нийт 43 албан хаагч хамрагдсан байна. 3. 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр цахимаар зохион байгуулагдсан mediuleg системийн шинэчлэлтэй холбоотой ЭБАТ-д зориулсан сургалтад нийт 20 ЭБАТ бүгд хамрагдсан. 4. 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр танхимаар зохион байгуулагдсан авлигын эсрэг сургалтад нийт 57 албан хаагч, 17 ЭБАТ, нийт 77 албан хаагч хамрагдсан байна. 5. 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр танхимаар зохион байгуулагдсан ЭБАТ-ийн сургалтад нийт 17 албан хаагч хамрагдсан байна. Харьяа зарим Эрүүл мэндийн	100%

						байгууллагуудын хувьд: 1. Эрүүл мэндийн хөшжлийн төв-2 удаагийн сургалтаар 26 албан хаагч, 236 эмнэлгийн мэргэжилтэн 2. Улсын нэгдүгээр төв эмнэлэг-2 удаагийн сургалтаар 266 эмнэлгийн мэргэжилтэн 3. Улсын хоёрдугаар төв эмнэлэг-2 удаагийн сургалтаар 504 эмнэлгийн мэргэжилтэн 4. Хавдар судлалын үндэсний төв-5 удирдах албан тушаалтан 5. Гэмтэл согог судлалын үндэсний төв-2 удаагийн сургалтаар 120 эмнэлгийн мэргэжилтэн 6. ЭНЭҮТ-II-3 удаагийн сургалтаар 311 эмнэлгийн мэргэжилтэн 7. Бусад эрүүл мэндийн байгууллагуудын хувьд цахимаар болон танхимаар сургалтуудыг авсан байна. Хавсралт : 1 файл	
5	2.2. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байдал.	2022 он			Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн "Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын 2022-2023 оны хичээлийн жилийн элсэлтийн шалгалтын комиссын бүрэлдэхүүн батлах тухай" А/472 дугаар тушаал батлагдсан. Тус тушаалаар батлагдсан 2022-2023 оны хичээлийн жилийн үндсэн мэргэшлийн элсэлтийн шалгалтын комиссын бүрэлдэхүүн, Шалгалтын бэлтгэл ажил хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тайлбар, мэдэгдэл гаргах чиглэлээр 5 удаагийн сургалтыг хийж, тус шалгалтаас өмнө гишүүн бүрээр тайлбар, мэдэгдлийг гаргуулсан. Мөн тус элсэлтийн шалгалт өгөхөөр бүртгүүлсэн 236 их эмч нарт зориулан цахимаар Авлига, ашиг сонирхлын зөрчил, хуурамч зар мэдээллээс болгоомжлох, хохирогч болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт хийсэн. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/46 дугаар тушаалаар томилогдсон Магадлан итгэмжлэлийн 30 шинжээчид зориулан Авлигын эсрэг сургалтыг зохион байгуулсан. Авлигад хамгийн их өртөх магадлалтай ажлын байран дээр болон үйл ажиллагаанд зориулан өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан тухай бүр сургалт хийн ажиллаж байна. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын Эрх бүхий албан тушаалтнууд ХАСУМ, ХАСХОМ гаргах тухай сургалтыг албан хаагч нарт тогтмол орж байна.	100%	

							Хавсралт : 8 зураг	
3. Авлигатай тэмцэх газраас гаргасан шийдвэрийг биелүүлэх								
6	3.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх.	2022 он					<p>Авлигатай тэмцэх газраас 2022 оны жилийн эцсийн байдлаар Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, Улсын нэгдүгээр төв эмнэлэгт тус тус хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах тухай зөвлөмжийг хүргүүлсэн байна.</p> <p>Зөвлөмжийн дагуу Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Менежментийн баг томилох тухай” А/66 дугаар тушаалын дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт менежментийн баг ажиллаж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. Үүний дагуу зөвлөмжийг хэрэгжүүлж, хариуг Авлигатай тэмцэх газарт 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 1а/2134 тоот албан бичгээр хүргүүлсэн. Албан бичгийг хавсаргав. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/281 дүгээр тушаалын дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлэгт Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна. Улсын нэгдүгээр төв эмнэлэгт илэрсэн зөрчлийг өөр бусад эрүүл мэндийн байгууллагад гарахаас сэргийлж, зөвлөмжийг 2022.05.24-ний өдрийн "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж ажиллах тухай" 2/2498 тоот албан бичгийг хүргүүлсэн. Албан бичгийг хавсаргав. Тус ажлын хэсэг УНТЭ-тэй хамтран ажиллаж Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 13 зөвлөмжийг хэрэгжүүлж Авлигатай тэмцэх газарт "Зөвлөмжийн хэрэгжилт хүргүүлэх тухай" 1а/3095 тоот албан бичгийг хавсралт 85 хуудсын хамт 2022.06.28-ний өдөр буюу Авлигатай тэмцэх газраас тогтоосон хугацаанд багтаан хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас өргөтгөсөн ажлын хэсэг гарч Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хяналт шалгалтыг 2022 оны 11 дүгээр сард эхлүүлсэн. Одоогийн байдлаар хяналт шалгалтын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон зөвлөмжийг ирүүлээгүй байна.</p>	100%

							Хавсралт : 4 файл	
7		3.2. Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	2022 он				<p>Тус яаманд 2022 оны жилийн эцсийн байдлаар Авлигатай тэмцэх газраас Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа Нийслэлийн түргэн тусламжийн төвд холбогдох мөрдөгчийн мэдэгдэл ирсэн байна. Авлигатай тэмцэх газрын 2022.03.22-ний өдрийн "Мэдэгдэл хүргүүлэх тухай" 06/3968 тоот албан бичгийн дагуу Нийслэлийн эрүүл мэндийн газарт зөрчлийг арилгуулж, эргэн мэдэгдэх тухай 1а/1423 тоот албан бичгийг 2022.03.31-ний өдөр хүргүүлсэн. Албан бичгийн дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд: - Төрийн албан хаагчийн болон Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, бусад журмыг сахиж, төрийн албаны болон мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх тухай, Албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр өөртөө давуу байдал бий болгохгүй байх тухай, Төрийн албаны тухай хууль болон Авлигын эсрэг хуульд заасны дагуу эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажил үүргийн хуваарь, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж хориглох зүйлүүд, албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авахыг хориглох тухай, Авлигын нийгмийн хор аюул, авлигыг үл тэвчих ёс суртахууны тухай зэрэг сэдвээр тус тус сургалт, сурталчилгааг давхардсан тоогоор нийт 388 албан хаагчдын дунд зохион байгуулсан байна. -Авлигаас урьдчилан сэргийлэх, хуульд заасан үүргээ биелүүлээгүй ажилтан, албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэх, ажлаас чөлөөлөх арга хэмжээ авах тухай Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, Хөдөлмөрийнгэрээнд холбогдох заалтуудад шинэчлэн тусгасан байна. 2022.04.07-ны өдөр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захиралтай холбоотой асуудлаар мөрдөгчийн мэдэгдэл ирсэн. Үүний дагуу Л.Насанцэнгэл нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрч, үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг харгалзан чөлөөлж, 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 2/2278 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хариуг хүргүүлсэн.</p>	100%

							Хавсралт : 3 файл	
8	3.3. Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	2022 он					<p>Авлигатай тэмцэх газраас 2022.05.26-ны өдөр ирүүлсэн 06/7375 тоот зөрчил арилгуулах албан бичгийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр үндсэн хөрөнгийн хагас жилийн тооллогоор Элемент ХХК дээр очиж бүртгэл тооллого хийхэд Төрийн өмчийн хорооны 2014 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 335 тоот тогтоолын дагуух тоног төхөөрөмжөөс 11,967,775 төгрөгийн үнэ бүхий жин /пүү/-гээс өөр тоног төхөөрөмж бодит байдал дээр байхгүй байсан. Энэ жин нь зэвэрч цоорсон ашиглалтнаас гарсан байсан ба төмрийн хогонд өгөх саналыг Элемент ХХК-аас гаргаж байсан. Бусад хөрөнгийг 2014 онд устгаж булшилсан гэсэн тайлбарыг компаний холбогдох албан тушаалтан өгсөн ба бичгээр бидэнд мэдэгдсэн. Иймд зөрчил арилгах албан бичгийн дагуу арга хэмжээ авах боломжгүй болсон. Энэ тухай авлигатай тэмцэх газарт мэдэгдсэн. Өөр зөрчил арилгуулах бичиг ирээгүй болно.</p>	100%
4. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх								
9	4.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдээс гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах.	2022 он					<p>Авлигатай тэмцэх газраас 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарыг Эрүүл мэндийн яаманд байршуулсан. Уг самбар дахь мэдээллийг 2 удаа шинэчилсэн. Уг самбарт иргэдээс Эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын хувьд авлигатай холбогдуулан гаргасан гомдол одоогоор ирүүлээгүй байна. Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 2022 оны жилийн эцсийн байдлаар эрүүл мэндийн салбартай холбоотой нийт 2225 гомдол, санал, хүсэлт, талархал ирсэн бөгөөд авлигатай холбогдуулан гаргасан гомдол ирээгүй байна. Эрүүл мэндийн салбарт иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг агуулгаар харахад: - Эмнэлгийн хүлээгдэл, эмнэлэгт үзлэгийн цаг захиалахтай холбоотой - Эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал, чанартай холбоотой - Эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа</p>	100%

						<p>хандлагатай холбоотой - Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой - Эрт илрүүлэг, үзлэг, оношилгоотой холбоотой - Эрүүл мэндийн байгууллагын авто зогсоолтой холбоотой - Санхүү, эрүүл мэндийн даатгал, хөрөнгө оруулалттай холбоотой - Бусад Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад Авлигатай тэмцэх газраас хяналт, шалгалт хийж, илрүүлсэн зөрчлийг арилгуулахаар Эрүүл мэндийн яамнаас ажлын хэсэг тухай бүр байгуулан, шуурхай ажиллаж зөрчлийг арилгуулж, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Үүнд ЭЭХХЗГ, УНТЭ, Өргөө амаржих газар ТМЭ, Хүрээ амаржих газар ТМЭ-т менежментийн багийг томилж ажиллуулсан. Илэрсэн зөрчлийг бусад эрүүл мэндийн байгууллагад гарахаас сэргийлж тухай бүр албан бичгээр чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн яамнаас 2022 оны жилийн эцсийн байдлаар Иргэн, Аж, ахуй нэгж, байгууллагатай Худалдах, худалдан авах, Ажил гүйцэтгэх, Хөлсөөр ажиллах, Эд хөрөнгө хөлслөх, Түрээс, Хамтран ажиллах зэрэг нийт 544 гэрээг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай хууль, Иргэний хууль болон бусад хуульд үндэслэн байгуулсан болно.</p> <p>Хавсралт : 1 зураг</p>	
10	4.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах.	2022 он			<p>Эрүүл мэндийн яамнаас 2022 оны жилийн эцсийн байдлаар Иргэн, Аж, ахуй нэгж, байгууллагатай Худалдах, худалдан авах, Ажил гүйцэтгэх, Хөлсөөр ажиллах, Эд хөрөнгө хөлслөх, Түрээс, Хамтран ажиллах зэрэг нийт 545 гэрээг Иргэний хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хуулийг удирдлага болгон байгуулсан болно. Эрүүл мэндийн яаманд Авлигатай тэмцэх газраас 2022 оны 09 дүгээр сард хяналт шалгалтаар ирж, гэрээ байгуулахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үндэслэл болгох тухай зөвлөмж өгсний дагуу тус хуулийг нэмж, гэрээний загварыг өөрчилсөн. Мөн зөвлөмжийн дагуу албан</p>	100%	

						<p>тушаалтныг шинээр томилох тушаалд ".....нд 30 хоногийн дотор Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг мэдүүлэхийг үүрэг болгосугай." гэх заалтыг нэмж оруулсан. Хавсралтаар жишиг гэрээг оруулав.</p> <p>Хавсралт : 1 файл</p>	
11	4.3. Авлигын эсрэг байгууллагын соёлыг төлөвшүүлэх, удирдлагын манлайлал үзүүлэх, санаачилга өрнүүлэх.	2022 он				<p>Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд Авлигын эсрэг мэдээллийн самбарыг ажиллуулж байна. Эрүүл мэндийн сайд С.Энхболд Эрүүл мэндийн салбарын шударга, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, авлига ашиг сонирхлоос ангид байх чиглэлээр Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллаж, арга зүйн дэмжлэг авч, эрүүл мэндийн салбарт бодит үр дүнг гарган ажиллах тухай албан бичгийг хүргүүлсэн. Авлигын эсрэг байгууллагын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр харьяа эмнэлгүүдэд Эрүүл мэндийн яамнаас баг гарган дэмжлэгт удирдлагаар ханган ажилласан. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах комиссар Б.Тэрбиш, ажилтан комиссар У.Номин-Эрдэнэ нар тус яаманд 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 11.00 цагт ирж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн зөвлөмж өгсөн. Энэ хүрээнд Эрүүл мэндийн яамнаас дараах арга хэмжээг зохион байгуулж, оролцсон байна. 1. 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Авлигатай тэмцэх газартай хамтран нийт харьяа 24 байгууллагын Эрх бүхий албан тушаалтны уулзалтыг зохион байгуулж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар санал солилцсон. 2. 2022.11.17-ны өдөр "Эрүүл мэндийн даатгал-Иргэний хяналт-Эмнэлгийн тусламж, үйлчилгээ" сэдэвт хэлэлцүүлэгт чиглүүлэгчээр болон илтгэл хэлэлцүүлж оролцсон. 3. Дээрх хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцүүлэхээр бэлдсэн байна. Хэлэлцүүлэг түр хойшлогдсон. 4. Гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой асуудлаар тус яамны Санхүү, эдийн засгийн газраас Авлигатай тэмцэх газарт мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна. 5.УГТЭ-ээс "Авлигын эсрэг хууль" болон "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын</p>	100%

						зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн мэдлэг сорих тэмцээнийг нийт албан хаагчдыг дунд зохион байгуулсан. Харьяа эмнэлгүүд нөөц бололцоондоо тулгуурлан ажлуудыг зохион байгуулж ажиллаж байна.	
5. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах							
12	5.1. Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээний талаар (И-Монголиад холбосон, автоматжуулсан үйлчилгээг оруулна) мэдээлэл.	2022 он				Төрийн үйлчилгээний нэгдсэн систем И-Монгол-д Эрүүл мэндийн яамнаас дараах 12 үйлчилгээний сервисийг гаргаж, ашиглалтад оруулав. Үйлчилгээний нэршлээр: 1. Шинжилгээний хариу 2. Жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудас 3. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас 4. Эмнэлэгт цаг авах 5. Эрүүл мэндийн даатгалын лавлагаа 6. Олон улсын эрүүл мэндийн аяллын гэрчилгээ 7. Эмнэлгийн магадлагаа 8. Дархлаажуулалтын гэрчилгээ 9. Ковид-19 шинжилгээний хариу 10. Ковид-19 QR батламж 11. Эрт илрүүлэг, үзлэг оношилгооны асуумж 12. Эрт илрүүлэг, үзлэг оношилгооны дүгнэлт Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох явцын цахим системийг нэвтрүүлсэн. Монгол улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 259 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, сунгах, нэр өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт хүлээн авах цахим системийг 2022 оны 4 дүгээр сараас эхлэн хүсэлт гаргасан эрүүл мэндийн байгууллага, ААН-ийн материалыг 100% цахим программ ашиглан хүлээн авч шийдвэрлэж байна. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудын мэдээний санг цахимжуулсан. 2022 оны 1 сараас эхлэн Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан эрүүл мэндийн байгууллагын материалыг 100% цахим программ ашиглан хүлээн авч шийдвэрлэж байна. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан цахимд шилжсэн байна.	100%

13	5.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд төрийн үйлчилгээний зохион байгуулалтыг өөрчилсөн, стандартыг шинэчилсэн талаар мэдээлэл.	2022 он			<p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд Монгол улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 259 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, сунгах, нэр өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт хүлээн авах цахим системийг 2022 оны 4 дүгээр сараас эхлэн хүсэлт гаргасан эрүүл мэндийн байгууллага, ААН-ийн материалыг 100% цахим программ ашиглан хүлээн авч шийдвэрлэж байна. Мөн 2022 оны 1 сараас эхлэн Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан эрүүл мэндийн байгууллагын материалыг 100% цахим программ ашиглан хүлээн авч шийдвэрлэж байна. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан цахимд шилжсэн байна. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/221 дүгээр тушаалаар Эмнэлгийн тусламж, үйлчилгээний түгээмэл үйлдлийн стандартыг шинэчлэх ажлын хэсгийг байгуулан, ажлын хэсэг ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын тушаалаар эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны бүтэц, дүрмийг шинэчлэн баталсан.</p>	100%
14	5.3. Хүнд суртал, чирэгдлийг бууруулах, шат дамжлагыг цөөрүүлэх зорилгоор өөрчлөлт оруулсан дүрэм, журмын талаар мэдээлэл.	2022 он			<p>2022 оны хагас жилийн байдлаар тайлагнасан дүрэм, журам дээр Эрүүл мэндийн салбарын цахим шилжилттэй холбоотой дараах ажил хийгдсэн байна. Цахим шилжилт нь төрийн байгууллагын хүнд суртал, чирэгдлийг бууруулах, шат дамжлагыг цөөрүүлэхэд хамгийн чухал ач холбогдолтой юм. 1. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтөд Эйбл софт ХХК-т 150 хэрэглэгчийн эрхийн гэрээг 2019 оноос хойш хийж эрүүл мэндийн салбарын 21 аймгийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн яамны 20 байгууллагатай албан хэрэг хөтлөлтийн ЭЙБЛ мэдээллийн системийг ашиглан албан хэрэг хөтлөлтийг саадгүй цаг алдалгүй явуулж байна. 2. Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд хийгдэж буй эрүүл мэндийн өгөгдөл солилцооны нэгдсэн платформ хөгжүүлж, нэвтрүүлэх хүрээнд дараах ажлууд хийгдэв. Үүнд: -Эрүүл мэндийн өгөгдөл, мэдээлэл технологийн стандарт боловсруулах ажлыг бүрэн хүлээн авав.</p>	100%

						<p>https://fhir.gov.mn/ -Эрүүл мэндийн салбарын 14 эмнэлзүйн программ хангамж үйлдвэрлэгч нартай мэдээлэл солилцох уулзалтыг зохион байгуулсан. -Үйлчлүүлэгчийн портал сайт хөгжүүлэх ажил бүрэн дуусаж, туршилт хийгдэж байна. -Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад зориулсан E-hospital программ хангамж дуусаж, админы сургалтыг зохион байгуулж 534 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ашиглаж мэдээллийг мэдээлэл солилцооны платформ /HIEP/-Д дамжуулж байна. - Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо, шинжилгээний хүрээнд 14 эмнэлзүйн программ хангамж хөгжүүлж байгууллагын төр, хувийн хэвшил нийлсэн Анхан болон лавлагаа шатлалын нийт 638 байгууллагын мэдээлэл нэг стандартаар цугларч мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ үүсч байна.</p>	
15	5.4. Авлигын эрсдэлийн үнэлгээ, үйл ажиллагаанд мониторинг, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулсан эсэх талаар мэдээлэл.	2022 он			<p>Эрүүл мэндийн яамнаас Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэрийг тухай бүрт нь хэрэгжүүлж, хуулийн хугацаанд хариуг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажилласан. Мөн Авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх магадлалтай ажлын байрны үйл ажиллагааг тодруулж, авлигаас ангид, зөрчилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд арга хэмжээ авч ажилласан. Үүнд; Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Глобаль сангийн дэмжлэгтэй Дох, сүрьеэгийн төсөл хэрэгжүүлэх нэгж зэрэг, Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв зэрэг эрүүл мэндийн байгууллагад Эрүүл мэндийн сайдын тушаалаар хяналт-шалгалт хийж, шаардлагатай тохиолдолд "Менежментийн баг" томилон ажиллуулж, үйл ажиллагааг нь мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Эрүүл мэндийн яамнаас Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэрийг тухай бүрт нь хэрэгжүүлж, бусад эрүүл мэндийн байгууллагад зөвлөмж хүргүүлж, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, Хүрээ амаржих</p>	100%	

						газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт дэмжин туслах баг томилж ажиллуулсан. Хяналт-шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдолд бусад эрүүл мэндийн байгууллагад зөвлөмж хүргүүлж, урьдчилан сэргийлж ажилласан.	
						Хавсралт : 5 файл	
6. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах							
16	6.2. Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-т заасан заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах.	2022 он				Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, Авлигын эсрэг хуулийн 6.1.4 дэх хэсэгт заасан мэдээллийг байгууллага, албан тушаалтан тогтмол мэдээлнэ гэж заасны дагуу Эрүүл мэндийн яамны moh.gov.mn цахим хуудаст Шилэн данс гэсэн цэсийг нэмж, уг цэс нь Сангийн яамны Шилэн данс системтэй шууд холбогдон мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Шилэн данс системд Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/63 дугаар тушаалын дагуу мэдээллийг Санхүү эдийн засгийн газрын хариуцсан мэргэжилтэн тухай бүр хариуцан оруулж байна. Мөн moh.gov.mn цахим хуудасны Ил тод цэсэнд Тендерийн баримт бичгийн ил тод байдал гэсэн дэд цэсийг ажиллуулж байна. Уг цэснээс тендерийн урилга, тендерийн мэдээллийг тухай бүр авах боломжтой. Тус яамгы Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2022 оны 09 дүгээр сард Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/63 дугаар тушаалын хэрэгжилт хяналт шинжилгээ хийсэн. Тус хяналт, шинжилгээний дагуу гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж, мэдээллийг цахимд бүрэн байршуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/63 дугаар тушаал батлагдсанаар цахимд мэдээлэл байршуулах албан тушаалтанг хариуцлагажуулж өгсөн давуу талтай. Хавсралтаар Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.	100%
						Хавсралт нийт : 4 Файл : 1 Зураг : 3	